

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол Улсын засгийн газрын 2010 оны 11 дүгээр  
тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

/2009 оны үйл ажиллагааны үр дүн/

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1.	Бодлогын зорилтын үр дүнгийн үнэлгээ	1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	93,6	4,68
		2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	75,4	3,77
		3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	90,6	4,53
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>86,5</b>	<b>4,32</b>	
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	90,0	4,50
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	91,8	4,59
		3. Монгол улсын ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	97,7	4,88
		4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	93,8	4,69
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>93,3</b>	<b>4,66</b>	
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	93,3	4,66
		2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	90,0	4,50
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>91,65</b>	<b>4,58</b>	
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100,0	5,00
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100,0	5,00
		3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	95,7	4,78
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал	99,0	4,95
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>98,6</b>	<b>4,93</b>	
5	Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ	1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	93,6	4,68
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	80,3	4,01
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>86,9</b>	<b>4,34</b>	

<b>Ерөнхий үнэлгээ</b>	<b>91,39</b>	<b>4,56</b>
------------------------	--------------	-------------

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан „Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам,-ын дагуу Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг, түүний Тамгын газрын 2009 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, тайлагнаж байна.

**Нэг. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

**1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт**

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг түүнд заагдсан стратегийн зорилтуудын хэрэгжилтээр гаргаж тайлагнаж байна.

Стратегийн 124 зорилтоос макро түвшинд хэрэгжилтийг тооцох зорилтуудыг хасч, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар хэрэгжилтийг зохион байгуулах 88 зорилтын хэрэгжилтийг тооцон гаргалаа. /ХШҮ-ний тайлангийн гуравдугаар хавсралт/

Эдгээр зорилтоос: 2009 оны хувьд 30,0 хувийн гүйцэтгэлтэй 2, 70,0 хувийн гүйцэтгэлтэй 6, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 24, 100,0 хувийн гүйцэтгэлтэй 56 зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн хувь нь 93,6, үнэлгээний оноо 4,68 байна.

Харин хэрэгжиж эхэлснээс хойш буюу Үндэсний хөгжлийн цогц бодлогоор дэвшүүлэн тавьсан тухайн зорилтын хэдэн хувийг хэрэгжүүлснийг ойролцоогоор тооцож дараахь үнэлгээг өгч байна. Үүнд, 30,0 хувийн гүйцэтгэлтэй 10, 50,0 хувийн гүйцэтгэлтэй 46, 70,0 хувийн гүйцэтгэлтэй 31, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 1 зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн хувь нь 55,2, үнэлгээний оноо 2,76 байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгах замаар хэрэгжилтийг зохион байгуулах учиртай гэж үзэж байгаа.

Одоогийн байдлаар тус аймагт дараахь хөгжлийн бодлогын баримт бичгүүд ашиглагдаж байна. Үүнд:

1. Дорноговь аймгийн Засаг даргын захиалгаар „Хот байгуулалт,, УҮГазар 2001 онд боловсруулсан „Дорноговь аймгийн хөгжлийн төсөл,, гэсэн баримт бичиг

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 18 дугаар тогтоолоор баталсан „Дорноговь аймгийн 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр,,

3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 18 дугаар тогтоолоор баталсан „Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр,,

4. Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2006-2015/

5. „Говийн бүсийн Таван толгой, Оюу толгой, Цагаан суврагын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөөний товч тайлбар,, 2008 он.

6. „Дорноговь аймгийн Ханги-Мандал боомтын „Ханги,, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө,, 2006 он.

7. „Сайншанд хотын хөгжлийн мастер төлөвлөгөө,, /2009 он/ зэрэг болно.

Замын-Үүд сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Монгол улсын Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолоор байгуулсан, ажлын хэсгийн ахлагчаар нь Монгол улсын сайд, Засгийн газрын ХЭГ-ын дарга ажиллаж байгаа. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ЗТБХБЯ-ны захиалгаар „Проект Х,, компани 2007-2009 онд боловсруулсан, үүнийг Замын-Үүдийн чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж шинэчлэн боловсруулах шаардлага тавигдаж, түүнд шаардагдах 200,0 сая төгрөгийг улсын төсвөөс шийдвэрлэсэн байна. Ингэснээр Замын-Үүдийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил дуусах шатандаа орж байгаа юм.

„Дорноговь аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө,, боловсруулах ажлыг 2010 оны 5 дугаар сард багтаан гүйцэтгэхээр ажлын хэсэг байгуулагдсан. Аймгийн Засаг даргын 2010 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн а/61 дүгээр захирамжаар байгуулагдсан уг ажлын хэсгийн ахлагчаар аймгийн ЗДТГ-ын дарга Б.Төмөрхуяг, нарийн бичгийн даргаар нь Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Э.Энхжаргал нар ажиллаж байна.

Дорноговь аймгийн хөгжлийн стратегийг боловсруулахад харгалзан үзэх гол асуудал нь Сайншанд хотод хүнд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, Зүүнбаян-Оюу толгойн төмөр замыг тавих зэрэг асуудал болно. Эдгээр нь одоогийн байдлаар эцэслэсэн шийдвэрт хүрээгүй, судалгааны түвшинд байгаа тул хөгжлийн бодлогод тусгах эсэх асуудал хүлээлтийн байдалд байгаа юм.

## **1.2. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:**

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, аймгийн Засаг даргад хамаарах 139 зорилтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж ирлээ.

Эдгээрээс: 0,0 хувийн гүйцэтгэлтэй 1, 10,0 хувийн гүйцэтгэлтэй 5, 30,0 хувийн гүйцэтгэлтэй 14, 50,0 хувийн гүйцэтгэлтэй 14, 70,0 хувийн гүйцэтгэлтэй 19, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 37, 100,0 хувийн гүйцэтгэлтэй 39, энэ онд ажил эхлээгүй буюу тайлагнах хугацаа болоогүй 10 зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн дундаж хувь нь 75,4, үнэлгээний оноо 3,77 байна.

Зорилт тус бүрийн гүйцэтгэлд хувь тавихдаа аймаг, нийслэлийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрх, төсөв хөрөнгийн боломж, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтын үр дүнд гүйцэтгэж болох ажлын хэдэн хувийг хийсэн, эсвэл хүсэн хүлээсэн үр дүнгийн хэдэн хувийг бий болгосныг тооцохыг хичээсэн болно. /Дөрөвдүгээр хавсралт/

Аймгийн Засаг дарга П.Ганхуяг Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн заалт бүрийг хэрэгжүүлж, аймгийнхаа иргэдийн хүсэн хүлээсэн зорилтуудыг ээлж дараатай шийдвэрлэх, Засаг төрийн болон орон нутгийн ИТХурал, Засаг даргын бодлого, зорилт, шийдвэр бүрийг бүрэн хэрэгжүүлэх итгэл, зүтгэлээр ажиллаж ирсэн болно.

2009 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан аймгийн ИТХурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцээд Засаг дарга үүргээ „бүрэн хангалттай,, биелүүлж ирсэн гэж үнэлсэн юм. /Тогтоолыг хавсаргав/

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтуудын хэрэгжилтийг тоймлон авч үзвэл:

**\* Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж, эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж, түүнээс олсон орлогоос иргэдэд хувь хишиг хүртээх** гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутгаас шалтгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хувь хишгийг холбогдох заавар журмын дагуу олгож байна.

**\* Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх** зорилтын хүрээнд:

Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Сайншандад аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн юм. Төслийг боловсруулснаас хойшхи богино хугацаанд уг төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон судалгааны ажил эрчимтэй хийгдэж байна. ЗТБХБЯ-ны мэдээллийн хэсэг, Үндэсний шинэтгэлийн Хорооны дарга Ч.Хашчулуун ахлагчтай баг, ЗТБХБ-ын сайд Х.Баттулга ахлагчтай ажлын хэсэг ирж ажилласан ба ОХУ, БНСУ, БНХАУ-ын хөрөнгө оруулагчид, сонирхогч талуудын төлөөлөл, нийт 200 гаруй хүнийг урьж танилцуулга хийн, хамтран ажиллах чиглэлээ тогтоогоод байна.

Уг төслийн хүрээнд: Таван толгой-Цагаансуврага-Зүүнбаянгийн төмөр зам тавих, Сайншандад газрын тос боловсруулах, коксын, битумын, зэс, төмрийн хүдэр, ган хайлуулах, цемент, гипсэн хавтан үйлдвэрлэх зэрэг үйлдвэрийг барихаар тусгасан байна. Төмөр зам 2012 онд ашиглалтанд орж, аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа 2013 оноос эхлэхээр тооцжээ. Мөн төмөр замын терминал, онгоцны буудал, 100 мянган орон сууц баригдаж, 374,0 мянган ажлын байр шинээр бий болох тооцоо бий.

Энэ оны хувьд тус аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихэд бодитой ололт ахиц гарлаа. Улсын төсвөөс 570.0 сая төгрөг, орон нутгаас 30.0 сая, Монгол шуудан банкнаас 180.0 сая төгрөг, нийт 780.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн нийт 49 иргэн, 11 аж ахуйн нэгж, байгууллагад зээлийн хөрөнгийг 100 хувь зарцуулан олгоод байна.

Ингэснээр блок болон тоосгоны үйлдвэр шинээр байгуулагдаж, хүнсний бүтээгдэхүүний цех 7, ХАА-н чиглэлээр фермерийн аж ахуй болон жижиг үйлдвэрлэл 12, барилгын материал, гэр ахуйн мод, төмөр эдлэлийн зэрэг жижиг үйлдвэрлэл 12, ахуйн үйлчилгээ 8, худалдааны үйлчилгээ 20 цэгээр нэмэгдэж, 112 ажлын байр шинээр бий болох боломж бүрдээд байгаа юм.

**\* Мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр, тухайлбал мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоогоор хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах** зорилтын хүрээнд:

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн „Малчин өрх бүр үйлдвэрлэгч,, зөвлөгөөн, тариаланчдын зөвлөлгөөнийг тус тус зохион байгуулж, эдгээр салбарыг хөгжүүлэх төр засгийн болон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, зорилтыг мэдээлж, цаашид хамтран ажиллах чиглэлээ тогтоосон юм.

2009 оны мал тооллогын дүнгээр 1076,9 мянган толгой мал тоолуулж, 2000 оноос хойш 2 дахь удаагаа сая толгой малтай боллоо. Мал сүрэг бүх төрлөөрөө өссөний дотор үхэр, хонь, ямааны өсөлтийн хувь 16,5-15,9 хувь байна

Сүргийн дотор сайжруулсан нутгийн үүлдрийн мал 236,2 мянга болж өмнөх оныхоос 33,5 хувиар, нутгийн шилдэг омгийн мал 112,1 мянга болж өмнөх оныхоос 31,4 хувиар тус тус өссөн нь малын тоог биш, таваарлаг чанарыг голлох хандлага бий болсныг харуулж байна.

Газар тариалангийн хөгжилд зохих ахиц гарлаа. 10 сумын агропарк ашиглагчтай гэрээ байгуулж, 21 удаагийн сургалт, семинар зохион байгуулж, „Шинэ Дорноговь„ хөгжлийн сангаас 7,7 сая төгрөгийн хөрөнгө гаргаж ОХУ-ын элит сортын үрийн төмс татан авч өрхийн тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн зэрэг үйл ажиллагааны үр дүнд газар тариалан эрхлэлтийн хэмжээ урьд жилүүдээс нэмэгджээ. Нийт 54 аж ахуйн нэгж байгууллага, 441 өрх, 54.5 га-д төмс, 38.4 га-д хүнсний ногоо тариалж 222.7 тн төмс, 201.0 тн хүнсний ногоо хураан авсан нь өмнөх жилийнхээс 2 дахин өссөн үзүүлэлт юм.

**\* Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах зорилтын хүрээнд:**

Юуны өмнө нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйчилгээг хууль тогтоомжийн дагуу, цаг хугацаанд нь бүрэн олгож ирлээ. Эрүүл, мэнд, соёл урлаг, боловсролын үйлчилгээг бүрэн хүргэх, үйлчилгээний нөхцлийг сайжруулахын төлөө бололцоотой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн болно.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 296 өрхийг ядуурлаас гаргахаар сонгон авч, мэргэжил олгох сургалтанд хамруулах, байнгын болон түр ажлын байранд зуучлах, хууль тогтоомжийн дагуу нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авлаа.

Хүн амын амьжиргааг дэмжих зорилтын нэг хэлбэр болох тэдний боловсрол, мэдлэгийн түвшнийг дээшлүүлж, амьдрах арга ухаанд сургах зорилгоор олон арван сургалт зохион байгуулагдсаны дотор өмнөд бүсийн төмөр зам байгуулахад ажиллах хүчин бэлтгэх зорилгоор ажилгүй 100 залуучуудыг тусгай курсээр төмөр замчны сургалтанд хамрууллаа.

Төсөл, хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн сан, багийн хөгжлийн сан, иргэдийн хандив тусламж, олон малтай өрхөд малчнаар ажиллуулсны хөлс зэрэг төрөл бүрийн арга замаар аймгийн хэмжээнд 103 өрхийг нийтдээ 4635 толгой малтай болгожээ. Үүний дотор хамгийн зохион байгуулалттай хэлбэр нь Италийн Айфо олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа „Тэгш дүүрэн„ төсөл юм. Тус төслийн 10,5 сая төгрөгийн хөрөнгөөр 3 сумын, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүхий тус бүр 15 өрхийг малжуулах арга хэмжээ авсан байна.

Ядуурлыг бууруулах бодлого, үйл ажиллагааны үр дүнд аймгийн хэмжээнд ядуу өрхийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 1,7 хувь, хүн амын тоо 1,3 хувиар буурсан дүнтэй байна.

„Эрүүл монгол хүн„ бодлогын хүрээнд иргэдийг жилд нэг удаа үнэ, төлбөргүй оношлогоо эмчилгээнд хамруулах, эрүүлжүүлэх, хяналтанд авах зорилгоор „Явуулын амбулатори„-ийг сумдад ажиллууллаа. Нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн энэ баг үзлэг оншлогоо болон 10 төрлийн шинжилгээ хийж явсан ба нийтдээ 13,4 мянган хүнийг хамруулж, 2545 өвчлөл илрүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбарын гол үзүүлэлтүүд сайжирсан дүнтэй байна. Эхийн эндэгдэл гараагүй, нялхсын эндэгдэл буурсан, халдварт өвчний гаралт өмнөх жилийнхээс 20,5 хувиар буурсан байна.

Боловсролын салбарын хувьд, 2009-2010 оны хичээлийн жил ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлын чухал үе бөгөөд энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 6 настай 933 хүүхэд хүлээн авч, тэдэнд эрдэм ном заах багш нарыг тусгайлан бэлтгэсэн юм.

**\*Төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Нэг цэгийн үйлчилгээг 2009 оны 7 дугаар сард нээж, аймгийн ЗДТГ-ын иргэдтэй харилцах асуудал болон үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Татварын хэлтэс, ХХҮХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн төлөөлөл байнга ажиллаж байна.

2009 оны 4, 10 дугаар саруудад бүх суманд аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг ажиллан, төрийн ажил, үйлчилгээнд үнэлгээ өгч, төр засгийн болон орон нутгийн бодлого, шийдвэр хэрхэн хэрэгжиж байгаа, бодлогын томоохон зорилтуудын эхлэл ямар байгаатай танилцаж, иргэдтэй уулзаж, төрийн албан хаагчдад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын Засаг дарга нарт төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй нээлттэй хүргэж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх шаардлага тавьж хэрэгжүүлж ирлээ. Аймгийн ЗДТГазар веб хуудсаа шинэчилж, Сайншанд сумын ЗДТГазар шинээр веб хуудас нээж, бодлого, үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд сурталчилж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны тухай „Боловсрол суваг,, телевизээр 14 удаагийн цуврал нэвтрүүлэг явуулж, төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагад 30 орчим мэдээ, мэдээлэл нийтлүүлж, иргэдэд зориулсан „Мэдээлэл,, сэтгүүл хэвлэн гаргасан зэрэг нь үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангахад чиглэгдсэн болно.

Аймгийн Засаг даргын 2009 оны 426 дугаар захирамжаар, „Иргэдийн санал хүсэлт, гомдол, мэдээллийг телефон утсаар хүлээж авах журам,,-ыг баталсан нь төрийн бүх шатны байгууллагын ажил, үйлчилгээнд иргэд олон нийт үнэлгээ өгөх, санал, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч барагдуулах боломжийг олгож байгаа юм.

Бодлого, зорилт, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, тасарсан, орхигдсон, хойшлогдсон асуудлыг шуурхай шийдвэрлэх бодлого баримталж, үүрэг даалгаварын биелэлтээр хариуцлага тооцох журмыг аймгийн Засаг даргын 2009 оны 169 дүгээр захирамжаар батлан мөрдөж байна.

Төрийн үйлчилгээг цалгардуулсан, үүрэг даалгаварыг бүрэн хэрэгжүүлээгүй төрийн 6 албан хаагчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангах шаардлагыг сум, агентлаг, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт тавьж, хэрэгжүүлж ирсэн болно.

### **1.3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт**

#### **1.3.1. Үндэсний хөтөлбөрүүд:**

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж, холбогдох, сум, агентлагуудаас хэрэгжилтийн тайланг улирал дутамд гаргуулан авч, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд оруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байгаа билээ.

Энэ удаа Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолын дагуу хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн тайланг тусад нь гаргаж хүргүүлж байна.

Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх тухай Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ХЭГ/1972 тоот албан бичгийг хүлээн аваад уг тоотын хавсралтанд байгаа хөтөлбөрүүдээс хяналтанд авагдаагүй, тус аймагт хэрэгждэггүй хөтөлбөрүүдийн нэрийг түүвэрлэж, бүртгэлд

шинээр оруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг чиглэлийг аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдэд өгсөн юм.

Одоогийн байдлаар тус аймагт 66 хөтөлбөр хэрэгжиж байна. Үүний дотор сүүлийн үед батлагдан гарч хяналтанд авагдсан 6 хөтөлбөрийн биелэлтийг тооцож эхлэх хугацаа болоогүй байгаа тул „Х.б., гэж тэмдэглэв.

Хэрэгжилтийн хувийг тооцсон нийт 60 хөтөлбөрөөс 2009 оны хувьд 30,0 хувийн биелэлттэй 1, 70,0 хувийн биелэлттэй 6, 90,0 хувийн биелэлттэй 31, 100,0 хувийн биелэлттэй 22, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 6 хөтөлбөр байна. Хэрэгжилтийн хувь 90,6, үнэлгээний оноо 4,53 байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт зорилтын хэрэгжилтийг ойролцоогоор тооцсоноор 10,0 хувийн биелэлттэй 1, 30,0 хувийн биелэлттэй 3, 50,0 хувийн биелэлттэй 12, 70,0 хувийн биелэлттэй 21, 90,0 хувийн биелэлттэй 23, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 6 хөтөлбөр байна. Хэрэгжилтийн хувь 70,6, үнэлгээний оноо 3,53 байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд зориулсан бага хэмжээний зардлаас өөр аливаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр урьдчилан төлөвлөсөн хөрөнгө байдаггүй, төсөвт тийм боломж байхгүй, харин явцын дунд сургалт семинарын зэрэг бага хэмжээний зардлыг аймгийн төсвийн ангилагдаагүй зардлаас гаргаж санхүүжүүлж ирсэн. Үүнээс үүдэн, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориудын ажил зохион байгуулдаггүй, явцын дунд бий болсон үр дүнг уг хөтөлбөрт холбогдуулан тайлагнаж байгаа нь улсын хэмжээнд байгаа нийтлэг үзэгдэл болно.

Гэвч төсөв хөрөнгийн боломж, гадаад дотоодын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөр, байгууллага, иргэдийн хандив тусламж зэрэг эх үүсвэрийг дайчилж, удаан хугацааны, тогтвортой баримт бичиг болох төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолын хавсралт „Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангах ажиллагаанд хөрөнгө зарцуулсан дүн, гэсэн хүснэгтийн загварыг бага зэрэг өөрчилж, хөтөлбөр болон төслүүдийг хоёр ангилж бичив. Учир нь хэдийгээр Үндэсний ямар нэг хөтөлбөрийг дэмжих зорилготой хэрэгжиж байгаа төсөл байсан ч тэрхүү төсөл нь дэмжиж байгаа хөтөлбөртэйгээ ижил нэртэй байдаггүй. Иймд тухайн эгнээнд эсвэл зөвхөн хөтөлбөрийн, эсвэл зөвхөн төслийн хөрөнгө бичигдэх тул хөтөлбөр болоод төсөлд зарцуулсан хөрөнгө нэг эгнээнд бичигдэх боломжгүй юм. Түүнээс гадна энэ хүснэгтэнд тус аймагт хэрэгжиж байгаа бүх төслүүдийг биш, харин 2009 онд хөрөнгө зарцуулсан, мөн түүнчлэн хэрэгжиж эхэлснээс хойш зарцуулсан хөрөнгө мэдэгдэж байгаа төслүүдийг түүвэрлэж орууллаа. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийг урьдчилан төлөвлөдөггүй, цаг үеийн боломжоор хөрөнгө зарцуулж ирсэн тул асуултын нэгдүгээр багана буюу „нийт зарцуулах хөрөнгө,-ийг үнэн зөв бөглөх боломж байхгүй байна. Иймд энэ баганыг ихэвчлэн хоосон орхив.

Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 2009 онд 1 тэрбум 33,4 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөсөн, үүнээс 1 тэрбум 5,0 сая төгрөгийг зарцуулсан, хөрөнгө зарцуулсан нь мэдэгдэж байгаа хөтөлбөрүүдэд тэдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлж хэлснээс хойш 11 тэрбум 474,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан ойролцоо тооцоо гарсан байна.

Үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийг боловсруулж, аймгийн Засаг даргын захирамжаар батлан хэрэгжүүлж байгаа тул тайланд Үндэсний болоод орон нутгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зарцуулсан хөрөнгийн тухай мэдээлэл давхцаж байгаа болно.

### **1.3.2. Төслүүд:**

Гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалттай 11 төсөл 2009 онд тус аймагт хэрэгжиж ирсэн байна. Эдгээр төслүүдээс 2009 оны тухайд, 70,0 хувийн биелэлттэй 1, 90,0 хувийн биелэлттэй 1, 100,0 хувийн биелэлттэй 9 төсөл байгаа ба хэрэгжилтийн хувь 96,3, үнэлгээний оноо 4,81 байна.

Хэрэгжиж эхэлснээс хойш нийт зорилтын 50,0 хувийг биелүүлсэн 1, 70,0 хувийг биелүүлсэн 2, 90,0 хувийг биелүүлсэн 1, 100,0 хувийн биелэлттэй 7 төсөл байна. Хэрэгжилтийн хувь 89,0, үнэлгээний оноо 4,45 байна.

Хугацаа дууссан төлсүүд цаашид үргэлжлэн хэрэгжих эсэх, хэрэв үргэлжлэн хэрэгжвэл ямар зорилтыг хэрэгжүүлэх нь тодорхойгүй байдаг тул тухайн төслийн хэрэгжиж эхэлснээс хойшхи үр дүнг ихэвчлэн 100,0 хувь гэж тооцов.

Ихэнх төслүүдийн удирдах нэгж нь төвд байрлаж, төсөв хөрөнгөө түүгээрээ захиран зарцуулдаг, санхүүгийн тайлан мэдээлэл нь төслийн нэгж дээрээ гардаг тул орон нутагт төсөл хэрэгжүүлж байгаа бүтэц нь санхүүгийн тодорхой эрх мэдэлгүй байдаг. Иймд төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулсан хөрөнгийн хэмжээ бүрэн гарах боломжгүй юм. Үндэсний хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн тухай хавсралт хүснэгтэнд зөвхөн орон нутагт мэдэгдэж байгаа хөрөнгийн хэмжээг бичив.

Төслүүдийг хэрэгжүүлэхэд 2009 онд 3 тэрбум 916,2 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөсөн, үүнийг бүрэн зарцуулсан, хөрөнгө зарцуулсан нь мэдэгдэж байгаа төслүүдийг хэрэгжүүлж хэлснээс хойш 5 тэрбум 33,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан ойролцоо тооцоо гарсан байна.

## **Хоёр. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ**

### **2.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан, аймгийн Засаг даргад хамаарах зорилтын хэрэгжилт:**

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хамаарсан 9 зорилтыг хяналтанд авч биелэлтийг зохион байгуулсан. Эдгээрээс: 70,0 хувийн гүйцэтгэлтэй 2, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 3, 100,0 хувийн гүйцэтгэлтэй 4 зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн дундаж хувь нь 90,0, үнэлгээний оноо 4,50 байна. /Тавдугаар хавсралт/

*Хэрэгжилтийн талаар зарим онцлог зүйлийг тэмдэглэвэл:*

\* Төмс, хүнсний ногоо тарих өрхийн аж ахуйг дэмжих 5.3 дахь зорилтын хүрээнд: Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан, „Дорноговь,, хөгжлийн сангаас 7,7 сая төгрөгийн хөрөнгө гаргаж, ОХУ-ын „Романа,, сортын сайн чанарын үрийн төмс 10 тн-ыг татан авч, өрхийн тариаланчдад олгосон, сумдын агропарк ашиглагчтай гэрээ байгуулсан, шинээр тариалан эрхлэхийг хүсэгчдэд сургалт зохион байгуулсан зэрэг нь өрхийн тариалан эрхлэгчдэд сайн дэмжлэг болсон байна. Түүний үр дүнд газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оныхоос 2 дахин өссөн юм.

\* Говь, хээрийн цөлжилт явагдаж байгаа бүс нутгуудад „Ус,, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 11.8 дахь зорилтын хүрээнд: Улсын төсвийн 9,0 сая төгрөгийн хөрөнгөөр 6 булгийг тохижуулсан, 5 сум өөрсдийн нөөцөөр 5 булгийн эхийг тохижуулан хашаажуулж хамгаалалтанд авсан, усны бүртгэл тооллого явуулсан,

улсын төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр 11 худаг, бусад төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 12 худаг шинээр гаргасан, 81 худаг сэргээн засварласан байна.

\* Орон нутгийн МСҮТ-үүдийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулах, үйл ажиллагааг нь дэмжих тухай 14.16.1. дахь зорилтын хүрээнд: МСҮТ-ийн хичээлийн байранд их засвар хийж, 720 кв.м талбай бүхий дадлагын байрыг барьж, сургалтын шинэ тоног төхөөрөмжөөр хангасан. Ингэснээр 2008-2009 оны хичээлийн жилд 932 суралцагчтай болж суралцагчдын тоо өмнөх жилийнхээс 14.7 хувиар нэмэгдсэн, хичээлийн сургалтын стандарт хангалт 91.5 хувьд хүрсэн зэрэг ололтыг нэрлэж болно.

## **2.2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт**

Бүрэн хэрэгжсэн зорилтуудыг хяналтаас хасч, шинээр ирж байгаа шийдвэр бүрийг хяналтанд авч байлаа. 2009 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Засгийн газрын 108 тогтоолын 142 заалт, Монгол улсын Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт, Засгийн газрын 6 удаагийн хуралдааны тэмдэглэлийн 11 заалт, 3 албан даалгаварын 16 заалт хяналтанд байлаа. Эдгээр шийдвэрийн гүйцэтгэлийн дундаж хувь нь 91,8, үнэлгээний оноо 4,59 байна.

Засгийн газрын тогтоол, шийдвэр бүрийг аймгийн удирдлагууд болон хэлтсийн дарга нарт танилцуулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн ажилтны нэрээр хяналтын бүртгэл хөтөлж ирлээ. Хугацаа алдсан, тасарсан шийдвэрийн тухай мэдээллийг аймгийн удирдлагуудад хүргүүлж, шаардлагатай асуудлыг Засаг даргын зөвлөлд танилцуулж, тухайн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авч ирсэн болно.

Төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, зорилт, шийдвэр сум, агентлагуудад хэрхэн хэрэгжиж байгаатай тухай бүр танилцаж, сар дутмын зөвлөгөөн дээр 2-3 агентлагийн дарга нараар мэдээлэл хийлгэж, сум, агентлагуудаас улирал бүрт тайлан гаргуулан авч байлаа. Сумын Засаг дарга, агентлагийн дарга нарын 2009 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхдээ төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, зорилт, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж ирснийг гол үзүүлэлт болгосон юм.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын даргын 2010 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 3/45 тоот албан бичгээр Засгийн газрын ХЭГ-т хүргүүлсэн болно. Түүний нэгдсэн дүнг энэ тайланд хавсаргав.

## **2.3. Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт:**

Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол улсын Ерөнхий сайдтай 9 зүйл бүхий батламж үйлдсэн бөгөөд түүнийг амжилттай хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

### **1. Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.**

Төр засгийн бодлого, зорилт, шийдвэрийг орон нутагт бүрэн хэрэгжүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргаж ажиллаж ирсэн. Үйл ажиллагааны хөтөлбөртөө Монгол улсын Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, аймаг, нийслэлд хамаарах зорилтуудыг бүрэн тусгаж, 139 зорилтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн юм. 2009 оны жилийн эцсийн байдлаар эдгээр зорилтын хэрэгжилтийн дундаж хувь нь 75,4, үнэлгээний оноо 3,77 байна.

Аймгийн иргэд, байгууллага, нэгжүүдээс бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх асуудлын талаар өргөн хүрээнд санал авч, нэн чухал асуудлуудыг үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгасан болно. Аймгийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, төсөв хөрөнгийн боломжийг бүрэн дайчилж, удирдлага, зохицуулалт, зохион байгууллалтын арга хэмжээ авч төр, засгийн болон нутгийн удирдлагын бодлого, зорилт, шийдвэрийг боловсруулж, хэрэгжүүлж байна. /100,0 хувь/

**2. Төр, засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль, ёсыг чандлан сахиж, Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.**

Гагцхүү хууль ёсыг дээдэлж, хуулийн хүрээнд шийдвэр гаргаж, түүний хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн. /100,0 хувь/

**3. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирээдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ.**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1-д „Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, үйлчилгээний нээлттэй, ил тод байх боломжийг бүрдүүлж, өдөр бүр “Нээлттэй хаалга” зарчмыг баримтална,, гэсэн зорилт дэвшүүлсэн юм. Энэхүү зорилтыг ханган биелүүлэх хүрээнд:

\* Аймгийн Засаг даргын Тамгын газарт „Нэг цэгийн үйлчилгээ,, нээсэн

\* Аймгийн орон нутгийн телевиз, радиогоор үйл ажиллагаагаа байнга сурталчилж, жилд 2-оос доошгүй удаа шууд ярилцлага явуулж байгаа

\* Сум, байгууллагуудад тогтмол ажиллаж, иргэд хөдөлмөрчдийн саналыг сонсч, шаардлагатай асуудлыг нь шуурхай шийдвэрлэж ирсэн

\* „Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай,, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, төрийн байгууллага бүрийн ил тод, нээлттэй байдлыг хангуулах арга хэмжээ авч ажиллаж байна. /100,0 хувь/

**4. Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авлига, хээл хахуулийг цээрлэн ажиллана.**

Эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох зарим салбарын ажилтнуудын зөвлөгөөн, семинар, сургалтыг энэ онд зохион байгууллаа. Тухайлбал, Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцсон уулзалт, сургалт, бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн „Малчин өрх бүр үйлдвэрлэгч,, зөвлөгөөн, тариаланчдын зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, эдгээр салбарыг хөгжүүлэх төр засгийн болон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, зорилтыг мэдээлж, цаашид хамтран ажиллах чиглэлээ тогтоосон юм.

Энэ оны хувьд тус аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихэд бодитой ахиц гарлаа. Нийт 780.0 сая төгрөгийн эх үүсвэр бүхий зээлийн сан ажиллуулж, 49 иргэн, 11 аж ахуйн нэгж, байгууллагад зээлийн хөрөнгийг 100 хувь зарцуулан олгосон юм. Үүний үр дүнд блок болон тоосгоны үйлдвэр шинээр байгуулагдаж, хүнсний бүтээгдэхүүний цех 7, ХАА-н чиглэлээр фермерийн аж ахуй болон жижиг үйлдвэрлэл 12, барилгын материал, гэр ахуйн мод, төмөр эдлэлийн зэрэг жижиг үйлдвэрлэл 12, ахуйн үйлчилгээ 8, худалдааны үйлчилгээ 20 цэгээр нэмэгдэж, 112 ажлын байр шинээр бий болох боломж бүрдсэн байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлд ч зохих ахиц гарч, хураан авсан ургацын хэмжээ өмнөх оныхоос 2 дахин нэмэгдсэн юм.

Мал сүрэг 5 төрөл дээрээ өсч, 1076,9 мянган мал тоолуулсан нь өмнөх оныхоос 15,5 хувиар нэмэгджээ.

Төвлөрсөн төсөвт төлөх татварын орлогын төлөвлөгөөг 100,7 хувь, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 106,9 хувиар биелүүлсэн, 2009 оны эцэст төсвийн өр, авлагагүй байх бодлогыг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн хувьд батламжаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн. Авилга, хээл хахуулиас ангид ажиллаж байгаа. /100,0 хувь/

**5. Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөгжлийг хангах арга хэмжээ авч, ажилгүйдэл, ядуурлыг бодитойгоор бууруулж ажиллана.**

Соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын байгууллагуудын үйлчилгээний нөхцлийг сайжруулах бололцоотой арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сан, аймгийн болон сумын орон нутгийн төсөв, байгууллага, иргэдийн хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр нийтдээ 10 тэрбум 145.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 99 төсөл, арга хэмжээ 2009 онд хэрэгжсэний ихэнхийг нийгмийн салбарын барилга объектууд эзэлж байгаа юм.

Тухайлбал, Сайншанд суманд „Саран хөхөө,, театрын барилга, Саруул дэнж хорооллын 960 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэн барьж, Нэгдсэн эмнэлгийн сантехник, лифтны засвар, аймгийн БТСХ-ны барилгын засвар, Даланжаргалан сумын соёлын төвийн засвар, Өргөн сумын төсөвт байгууллагыг инженерийн шугам сүлжээнд холбох, Замын-Үүд сумын хүүхдийн цэцэрлэгийн цэвэр усны шугамын засвар зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлжээ.

АБТДО /амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлого/-той иргэдийн нийт хүн амд эзлэх хувь өмнөх оныхоос 2,1 функтээр буурч, 18,7 болсон байна. Энэ нь улсын дунджаас нилээд доогуур үзүүлэлт юм. Ядуурлыг бууруулах талаар зохион байгуулсан гол ажил нь малгүй буюу цөөн малтай иргэдийг малжуулах явдал байлаа. Аймгийн хэмжээнд 103 өрхийг нийтдээ 4635 толгой малтай болгосон байна.

Түр ажлын байрны тоо өмнөх оныхоос 37,5 хувиар нэмэгдэж, сумдад нэн шаардлагатай зорилтуудыг сонгох, ажилгүй болон ядуу иргэдийг нийтийг хамарсан ажилд оролцуулах талаар онцгойлон анхаарч ажилласан болно. Харин шинээр нээгдсэн байнгын ажлын байрны тоо өмнөх оныхоос нэмэгдсэнгүй. Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар олгосон зээл оройтсон, 2009 онд багтаж үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөх, шинээр нээх асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүйтэй холбоотой юм. /90,0 хувь/

**6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга, хариуцлагыг өндөржүүлж ажиллана.**

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар 2009 онд дэвшүүлсэн зорилтууд амжилттай хэрэгжсэн байна. Мал хулгайлах гэмт хэрэг өмнөх оныхоос 26,5 хувиар, захиргааны хэрэг, зөрчлийн тоо 49,6 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 31,5, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлт 16,6, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт 20,1, сургалт сурталчилгаа 7,0 хувиар тус тус өсчээ. Харин бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос 4,8 хувиар өссөн байна.

Сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 03 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж байна. /90,0 хувь/

**7. Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад ажилтнаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг, туслалцаа авч ажиллана.**

Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдээс бүрэн хэрэгжсэн зорилтуудыг хяналтаас хасч, шинээр ирж байгаа шийдвэр бүрийг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн. Хугацаа алдсан, тасарсан шийдвэрийн тухай мэдээллийг хяналт шинжилгээ, үнэлгээнийхээ нэгжээс тухай бүр авч, хэрэгжилтийг эрчимжүүлэх, нөхөн биелүүлэх арга хэмжээ авч байна. Шаардлагатай асуудлыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэдэг.

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад ажилтнаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж байгаа. Орон нутагт ажилласан төр, засгийн тэргүүн, Засгийн газрын гишүүдэд ажлаа дэлгэрэнгүй танилцуулж, тулгамдсан асуудлаа ойлгуулан зохих туслалцаа, дэмжлэг авч ажиллаж ирсэн болно.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн тухай Монгол улсын хуулинд Дорноговь аймгийн талаар тусгах саналыг холбогдох яам, газруудад албан бичгээр тавьж, сайд, дарга нартай биечлэн уулзаж, асуудлаа ойлгуулж, шийдвэрлүүлж байлаа. /100,0 хувь/

**8. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж алба тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авилга, хээл, хахуульд холбогдсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ.**

Дээр дурдсан зөрчил дутагдлыг гаргаагүй. Төрийн албыг хуулийн хүрээнд, ёс төртэй эрхлэн явуулах мэдлэг, чадвар, туршлага хуримтлуулсан хүний хувьд цаашид ч дээрхи хэлбэрийн зөрчил дутагдлаас ангид байж чадна гэж үзэж байгаа. /100,0 хувь/

**9. Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил дутамд Засгийн газарт тайлагнана.**

Батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил дутамд Засгийн газарт үнэн зөвөөр тайлагнаж байгаа. /100,0/

Батламжийн зорилтуудын хэрэгжилтийн дундаж хувь 97,7, үнэлгээний оноо 4,88 байна.

## **2.4.Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны „Шинэ Дорноговь,, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:**

Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны „Шинэ Дорноговь,, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2009 онд хэрэгжүүлэхээр 398 зорилт тусгасан. Үүнээс: 0,0 хувийн гүйцэтгэлтэй 3, 30,0 хувийн гүйцэтгэлтэй 3, 50,0 хувийн гүйцэтгэлтэй 5, 70,0 хувийн гүйцэтгэлтэй 21, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 102, 100,0 хувийн гүйцэтгэлтэй 260, хэрэгжилтийг тооцох боломжгүй буюу хугацаа болоогүй 4 зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн дундаж хувь нь 93,8, үнэлгээний оноо 4,69 болно.

„Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх тухай,, аймгийн ИТХ-ын 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 4/03 дугаар тогтоолоор дээрхи хувийг баталгаажуулж, „бүрэн хангалттай,, гэсэн үнэлгээ өгсөн болно. /Зургадугаар хавсралт/

### **2009 онд зохион байгуулж хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа:**

Аймгийн Засаг дарга сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд, төсөвт байгууллагууд, төрийн бус байгууллага, иргэдийнхээ оролцоо, дэмжлэгтэйгээр 2009 онд дараахь гол арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.

\* Нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйчилгээг хууль тогтоомжийн дагуу, цаг хугацаанд нь бүрэн олгож, зөрчилгүй ажилласан.

\* Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 296 өрхийг ядуурлаас гаргахаар сонгон авч энэ зорилтыг ханган биелүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 63 иргэнийг мэргэжил олгох сургалтанд хамруулж, 32 иргэнийг байнгын, 695 иргэнийг нийтийг хамарсан ажил буюу түр ажлын байраар хангажээ. Хүн амын 18,7 хувь нь АБТДО /амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлого/-той байгаа нь өмнөх жилийнхээс 2,1 хувиар буурсан үзүүлэлт юм.

\* Хүн амын амьжиргааг дэмжих зорилтын нэг хэлбэр болсон мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх, амьдрах арга ухаанд сургах олон удаагийн сургалтууд зохион байгуулагдсаны дотор өмнөд бүсийн төмөр зам байгуулахад шаардагдах ажиллах хүчин бэлтгэх зорилгоор ажилгүй 100 залуучуудыг тусгай курсээр сургалтанд хамруулсан нь нэн шаардлагатай, үр дүнтэй сургалт болжээ.

\* Төсөл, хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн сан, багийн хөгжлийн сан, иргэдийн хандив тусламж, олон малтай өрхөд малчнаар ажиллуулсны хөлс зэрэг төрөл бүрийн арга замаар аймгийн хэмжээнд 103 өрхийг нийтдээ 4645 толгой малтай болгожээ. Үүний дотор хамгийн зохион байгуулалттай хэлбэр нь Италийн Айфо олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа „Тэгш дүүрэн,, төсөл юм. Тус төслийн 10,5 сая төгрөгийн хөрөнгөөр 3 сумын, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүхий тус бүр 15 өрхийг малжуулсан байна

\* „Эрүүл монгол хүн,, хөтөлбөрийн хүрээнд иргэдийг оношлогоо эмчилгээнд хамруулах, эрүүлжүүлэх, хяналтанд авах ажлыг зохион байгууллаа. Түүний нэг хэлбэр нь „Явуулын амбулатори,, байлаа. Нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн баг сумдад ажиллаж, үзлэг, оношлогоо, шинжилгээ хийж явсан ба нийтдээ 13,4 мянган хүнийг хамруулж, 2545 өвчлөл илрүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

\* БНСУ-ын нарийн мэргэжлийн 50 гаруй эмч, мэргэжилтэн, сайн дурын ажилтан Сайншанд суманд ирж, 2400 хүнд үзлэг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсний дотор 18 хүнд үнэ төлбөргүй хагалгаа хийж, 1 хүний эмчилгээний зардлыг бүрэн хариуцан Солонгос улсад мэс засал хийлгэлээ.

\* „Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай,, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ирлээ. Аймгийн ЗДТГ-ын хэлтэс болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд сар бүр тодорхой уриа, сэдвийн дор нийтийг хамарсан уралдаан тэмцээнийг зохион байгуулж ирсэн ба нийт 12 удаагийн уралдаан тэмцээнд 113 байгууллага, 858 тамирчид оролцсон байна.

\* 2009-2010 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид 6 настай 933 хүүхэд хүлээн авч, багш нарыг тусгайлан бэлтгэсэн байна. Аймгийн Засаг даргын шийдвэрээр математикийн улсын 45 дугаар олимпиадыг доктор, профессор Х.Гэндэнжамцын нэрэмжит болгож, аймагтаа зохион байгууллаа. Энэ олимпиадад 21 аймаг, нийслэл хотоос 220 шахам сурагч, 65 багш ирж оролцсон юм.

\* Сумдын „Гэгээрэл,, төвүүд боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх сургалтанд 73, амьдрах ухаан, хөдөлмөрийн дадал олгох сургалтанд 715, мэдээлэл, компьютерийн сургалтанд 111, гадаад хэлний сургалтанд 152, бусад төрлийн сургалтанд 140, бүгд 1200 гаруй хүнийг суралцуулж, мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн байна.

\* Аймгийн төв номын сан болон сумдын номын сангуудыг иргэдийн хөгжил, мэдээллийн төв болгох эхний алхмуудыг хийлээ. Төв номын санд шинэ программ хангамж нэвтрүүлэх, дотоод сүлжээнд холбох, мэдээллийн танхим байгуулахад нь зориулж орон нутгийн төсвөөс 10 сая төгрөг, гадаадын байгууллагын тусламжаар 20 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэсэн юм. Сумдын номын сангуудад төслийн хөрөнгөөр тус бүр 1,0 сая төгрөгийн шинэ ном олгож, санг өргөтгөв.

\* „Саран хөхөө,, театрын уран бүтээлчид „12 сар,, „Эх орондоо харих болтугай,, драмын жүжиг, „Талын эсгэрээ,, баяр наадмын хүндэтгэлийн концерт, Халх голын ялалтын 70 жил, Ардчилсан хувьсгал ялсны 20 жилийн ойн хүндэтгэлийн концерт зэрэг 6 уран бүтээл туурвиж, 25 удаагийн тоглолт хийж, 8000 гаруй хүнд соёлын үйлчилгээ үзүүлсэн байна.

\* Жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихэд бодитой ололт ахиц гарлаа. Улсын төсвөөс 570.0 сая, орон нутгийн төсвөөс 30.0 сая, „Монгол шуудан,, банкнаас 180.0 сая, нийт 780.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн 49 иргэн, 11 аж ахуйн нэгж, байгууллагад зээлийн хөрөнгийг 100 хувь зарцуулан олгоод байна. Ингэснээр блок болон тоосгоны үйлдвэр шинээр байгуулагдаж, хүнсний бүтээгдэхүүний цех 7, ХАА-н чиглэлээр фермерийн аж ахуй болон жижиг үйлдвэрлэл 12, барилгын материал, гэр ахуйн мод, төмөр эдлэлийн зэрэг жижиг үйлдвэрлэл 12, ахуйн үйлчилгээний цэг 8, худалдааны үйлчилгээний цэг 20 шинээр нэмэгдэх боломж бүрджээ.

\* Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сан, аймгийн болон сумын орон нутгийн төсөв, байгууллага, иргэдийн хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр нийтдээ 10,145.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 99 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Хөрөнгө нь бүрэн шийдвэрлэгдсэн төсөл арга хэмжээнүүд 100,0 хувь ашиглалтанд орсон байна.

\* Иргэдийн оролцоонд тулгуурлаж сонгож авсан 50 төсөл, арга хэмжээ „Тогтвортой амьжиргаа-2,, төслийн хүрээнд хэрэгжиж, нийт 370,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Орон нутгийн захиргаа, иргэд эдгээр төсөл арга хэмжээг оролцооны аргаар сонгож, хувь нийлүүлсэн тул түүний гүйцэтгэлд тавих хяналт сайжирч, тухайн суманд хамгийн үр дүнтэй, нэн хэрэгцээтэй асуудлуудаа шийдвэрлэж ирсэн байна.

\* Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцсон уулзалт, сургалт, бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн „Малчин өрх бүр үйлдвэрлэгч,, зөвлөгөөн, тариаланчдын зөвлөлгөөнийг тус тус зохион байгуулж, эдгээр салбарыг хөгжүүлэх төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого, зорилтыг мэдээлж, цаашид хамтран ажиллах чиглэлээ тогтоосон юм.

\* Газар тариалангийн хөгжилд зохих ахиц гарлаа. 10 сумын агропарк ашиглагчтай гэрээ байгуулж, 21 удаагийн сургалт, семинар зохион байгуулж, „Шинэ Дорноговь,, хөгжлийн сангаас 7,7 сая төгрөгийн хөрөнгө гаргаж ОХУ-ын элит сортын үрийн төмс 10,0 тн-ыг татан авч өрхийн тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн юм. Ингэснээр газар тариалан эрхлэлтийн хэмжээ урьд жилүүдээс нэмэгджээ. Нийт 54 аж ахуйн нэгж байгууллага, 441 өрх, 54.5 га-д төмс, 38.4 га-д хүнсний ногоо, тэжээлийн ургамал 7.3 га-д тус тус тариалж, 222.7 тн төмс, 201.0 тн хүнсний ногоо хураан авсан нь өмнөх жилийнхээс 2 дахин нэмэгдсэн байна.

\* Дэд бүтэц, хот байгуулалтын талаар дэвшүүлсэн зорилтууд амжилттай хэрэгжиж ирлээ. „Чандмань илч,, ОНӨ ХХК 300,0 сая төгрөгийн зээл авч, төв зуух болон Айраг, Иххэт, Өргөн, Зүүнбаян багийн зуухнуудад нэн шаардлагатай засвар, үйлчилгээг хийснээр дулааны хангамж, цэвэр усны үйлчилгээнд ахиц гарсан байна.

\*Сайншанд хотын доторхи 3,0 км урттай гол авто замуудыг орон нутгийн боломжийг ашиглан хөнгөвчилсөн хучилттай болголоо. Сайншанд-Зүүнбаян-Хөвсгөл-Ханги Мандалын авто замын зураг төслийг 1,0 сая юанийн хөрөнгөөр, БНХАУ-ын талаар хийлгэлээ.

\*Хууль тогтоомжийн дагуу орон сууцны зориулалтаар газар олгох, нийтийн болон хувийн орон сууцанд дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ оруулах ажил үргэлжлэн хийгдэж, аймгийн хэмжээнд 82 айлын нийтийн орон сууцны барилга ашиглалтанд орсон байна.

\* Төсөв, санхүү, татварын бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжиж байна. 2009 онд 7 тэрбум 481,6 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 100,7 хувиар буюу 7,1 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 106,9 хувиар буюу 450,8 сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Татвар төлөгчдийн тоо 20275 болж, өмнөх оныхоос 5,7 хувиар нэмэгдсэн байна.

\* Цөлжилттэй тэмцэх хүрээнд хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт бол Мандах сумын төвд Солонгос улсын DAESUNG /ДАЕСАНГ/ компанийн хэрэгжүүлсэн төсөл болно. Уг төслийн хүрээнд 2 га газрыг зүлэгжүүлэх, мод тарих, 0,04 га газарт хүлэмж байгуулах, 2 хиймэл нуур байгуулж, нарны 100 кВт-ын эрчим хүчний эх үүсвэр тавих зэрэг ажлыг хийжээ.

\* Орон нутгийн төсвөөс 5,6 сая, аж ахуйн нэгж байгууллагаас 13,3 сая, нийт 18,9 сая төгрөгийн хөрөнгө гаргаж, нийт 52,0 мянган мод, бут, сөөгийг 26.9 га талбайд тариалсан дүн гарчээ. Үүний дотор 23,7 мянган суулгацыг БНХАУ-ын найрамдалт харилцаат муж, хотуудаас тусламжаар авсан байна.

\* Аялал, жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд, БНХАУ-ын Эрээн хотын даргатай „Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх,, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Уг хэлэлцээрт хоёр талын хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөнгөн шуурхай хандах, Дорноговь аймгийн нутагт Хятадын жуулчдыг нэг болон олон өдрийн аялал хийлгэх, Эрээн-Замын-Үүдийн өдрийн аялалыг үйлчилгээний өндөр чанартайгаар зохион байгуулах, үүний тулд тус боомтуудад жуулчдад зориулсан тусгай гарцыг ажиллуулах зэрэг заалтуудыг тусгасан байна.

\* Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төслийн хүрээнд 20,0 мянган долларын өртөгтэй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг аймгийн Засаг даргын Тамгын газарт байрлуулан „Нэг цэгийн үйлчилгээ,,-г 2009 оны 7 дугаар сард нээлээ. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын Засаг дарга нарт төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй нээлттэй хүргэж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх шаардлага тавьж хэрэгжүүлж ирлээ.

\* Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд, Өмнөд хөрштэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх чиглэлээр олон удаагийн уулзалт, харилцан айлчлал хийгдсэний дотор бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Хатанбулаг сумын Ханги Мандалын боомтыг байнгын ажиллагаатай болгох, тус боомтод хилийн цогцолбор, 24 айлын сууц, цэвэр, бохирын шугам тавих, Сайншанд-Зүүнбаян-Хөвсгөл-Ханги Мандалын авто замын зураг төсөл боловсруулах зэрэгт хамтран ажиллахаар тохирсон юм. Одоогийн байдлаар боомтын барилгын ажил 70 хувьтай, замын зургийг бүрэн дуусгаж хүлээж аваад байна.

\*Япон, БНСУ-тай тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа шинэ агуулгаар баяжиж, тодорхой асуудлуудаар төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Түүнээс гадна, шинэ түншүүдтэй болох зарим эхлэл ч тавигдлаа. ОХУ-ын Буриад улсын Иволгийн районотой холбоо тогтоож, харилцан айлчлал хийсэн, Бүгд найрамдах Болгар улсын Ардын их хурлын гадаад бодлогын байнгын Хорооны дарга тус аймагт айлчилсан, Чех улсаас Монгол улсад суугаа элчин зөвлөх ноён Мах тэргүүтэй төлөөлөгчид тус аймагт айлчилсан, Англи улсын Орон нутгийн байгууллагуудын холбоо, Австрали улсын Квинсланд мужтай холбоо тогтоох эхлэл тавигдсан байна.

\*Батлан хамгаалах хууль, тогтоомжуудаар аймгийн Засаг даргад хүлээлгэсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ирсэн байна. 2009 оны 3 дугаар сард аймгийн ЗДТГ-ын дарга, Цэргийн штабын дарга, сумдын ЗДТГ-ын дарга нарын баг өөрийн аймгийн дайчид алба хаадаг Сүхбаатар аймгийн Онгон сум дахь хилийн цэргийн 0184 дүгээр анги, түүний харъяа 8 заставт танилцах аялалд оролцсон, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартай хийх команд, штабын сургуулийг 2009 оны 6 дугаар сард зохион байгуулсан, Халхын голын ялалтын 70 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд, уг байлдаанд оролцсон дизизүүдийн туг хүлээн авах ёслолын ажиллагааг 2009 оны 6 дугаар сард Сайншанд хот, Зүүнбаян баг дахь Зэвсэгт хүчний 336 дугаар ангид зохион байгуулсан зэрэг нь батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагааны хэлбэр болсон юм.

\* Аймгийн Засаг даргын 2009 оны 12 дугаар захирамжаар аймгийн төвийн томоохон албан байгууллагуудыг хилийн отряд, заставуудтай түншлэлийн харилцаа тогтоож, улсын хил хамгаалалтанд туслах хүчний зөвлөлийг аймгийн Засаг даргын 2009 оны 13 дугаар захирамжаар шинэчлэн баталсан, аймгийн хэмжээнд хилийн цэрэгт туслах хүчнийг улсын хил хамгаалалтад оролцуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, баталсан байна.

\*Гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах чиглэлээр олон арга хэмжээ зохион байгууллаа. „Гамшгаас хамгаалах арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд сумын удирдлага, штабуудын үүрэг, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах арга хэмжээний тухай,, сэдэвт сургалтыг 2009 оны 4 дүгээр сард зохион байгуулж, сумдын Засаг дарга, Сайншанд сумын багуудын Засаг дарга нар, зарим албад, мэргэжлийн ангиудын дарга, нийт 30 гаруй хүнийг оролцууллаа. Сургалтын үеэр томилгоот бүрэлдэхүүний бэлэн байдал, хүн, малын гоц халдварт өвчний үед авах арга хэмжээний талаар үзүүлэх сургууль зохион байгуулсан байна. Мөн 2009 оны 11, 12 дугаар сард аймгийн Засаг даргын нэрэмжит, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг,, зохион байгуулж, нийт 51 байгууллага, мэргэжлийн ангиудыг хамрууллаа.

Хэрэгжилтийн хувь багатай байгаа зорилтууд, тэдгээрийн шалтгаан:

**1.2.4. /51/ Хөвсгөл сумын сургуулийн хичээлийн байранд их засвар хийнэ.** 2009 онд төсөв хөрөнгийн боломж бүрдээгүй. Холбогдох яам, төсөл, хөтөлбөрийн газарт санал, тооцоог хүргүүлсэн, одоогийн байдлаар 36,0 сая төгрөгийн хөрөнгийн боломж бүрдээд байгаа. Энэ зорилтыг 2010 онд хэрэгжүүлнэ.

**1.4.13. /114/ Хүүхдийн сувилал, зуслан ажиллуулах санаачлага гаргасан иргэд, байгууллагыг дэмжиж ажиллана.** Энэ чиглэлээр санаачлага гаргасан байгууллага, иргэн одоогоор байхгүй байна. Хүүхдийн „Жаргалан,, зуслангийн байршил зохимжгүйгээс амрах хүүхдийн тоо цөөн байдаг. Иймд энэ зусланг аймгийн төвд ойртуулах, гэрээ түрээсийн хэлбэрээр ажиллуулах санаачлага гарвал аймгийн ЗДТГ дэмжиж ажиллахад бэлэн байгаа .

**2.1.14. /144/ Малчдад чиглэсэн даатгалын төрлүүдийг хэрэгжүүлэн мал сүргийг индексжүүлсэн даатгалд хамруулна.** Индексжүүлсэн даатгалыг цөөн аймагт төслийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг, энэ төсөл тус аймагт 2009 онд

хэрэгжих эсэхийг сайн судлаагүй, өөрөөр хэлбэл нөхцөл байдлыг дутуу үнэлснээс хэрэгжих боломжгүй зорилтыг тусгасан байна.

**2.3.12. /177/ Мал нядалгааны төвлөрсөн цэг байгуулах аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгыг дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулна.** Сайншандын хэрэглэгчдийг махаар хангаж байсан „Дорнын говь,, ХХК аймагтаа үйл ажиллагаа явуулахаа зогсоосноос хойш зориулалтын бус газарт нядалсан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаагүй махыг ченжүүдийн гараар дамжуулан хэрэглэж байгаа юм. Энэ байдлаас гарахын тулд төвлөрсөн нядалгааны цэг байгуулах шаардлагатай байгаа юм. 2009 онд зарим иргэн ийм санаачлага гаргасныг дэмжиж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлд хамруулаад байгаа юм.

**2.3.17. /190/ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах биржийн сүлжээ байгуулах ажлыг судалж хэрэгжүүлэх санаачлагыг бүх талаар дэмжинэ.** Одоогоор түүхий эд бэлтгэн нийлүүлэх үйлчилгээ ченжүүдээр дамжин хэрэгжиж байна. Жилдээ ойролцоогоор 540,0 сая төгрөгийн түүхий эд, арьс шир, ноос ноолуур зах зээлд нийлүүлэгдэж байгаа юм. Цаашид түүхий эд бэлтгэн нийлүүлэх төвлөрсөн цэг байгуулах санаачлагыг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулах бодлого барьж, санаачлагыг дэмжиж ажиллах болно.

**2.4.16. /210/ Замын-үүд сум дахь шингэн ачаа шилжүүлэн ачих байгууламжийн элс зайлуулах экскаватортой болгоно.** 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтанд Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын багцад 50,0 сая төгрөгийн хөрөнгө тусгагдсан байсан. Энэ хөрөнгө төсвийн тодотголоор хасагдсанаас зорилт хэрэгжээгүй

**2.4.9. /204/ Замын-Үүд суманд дулааны станц барих ажлыг эхлүүлнэ.**

2009 онд хөрөнгийн боломж бүрдээгүйгээс энэ асуудал шийдвэрлэгдэж эхлээгүй. Тус сумын дулааны станцын техник, эдийн засгийн үндэслэлийг „Мон энерги консалт,, ХХК хийж байгаа. БНХАУ-ын Засгийн газрын 300,0 сая долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн зохих хэсгээр энэ асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газар шийдвэрлэсэн.

**2.5.3. /224/ Замын-Үүд сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэн барина.** 2009 онд төлөвлөсөн хөрөнгө төсвийн тодотголоор хасагдсан. Харин 2010 онд улсын төсвийн 350,0 сая төгрөгийн хөрөнгийг энэ барилгын санхүүжилтэнд шийдвэрлээд байгаа.

**2.5.4 /226/ Алтанширээ сумын сургуулийн дотуур байрны барилга шинээр барих асуудлыг гадаадын төсөл, хөтөлбөрт санал тавих замаар шийдвэрлүүлнэ.** Асуудлыг холбогдох Яам, төслийн газарт тавьсан боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Бололцоог дутуу судалсан, төлөвлөлтийн алдаа байсан гэж үзэж болно

**2.5.2. /223/ Сайншанд суманд Ёс заншил, ёслол хүндэтгэлийн өргөөг барьж эхэлнэ.** Уг барилгын хөрөнгө нь 2009 оны төсвийн тодотголоор хасагдсан, одоогийн байдлаар зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. 2010 оны улсын төсөвт 200,0 сая төгрөгийн хөрөнгө тусгагдсан тул 2010 онд бүрэн шийдвэрлэнэ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс гадна тухайн жилд хэрэгжүүлэх зорилтуудыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлж байгаа билээ.

Аймгийн ИТХурал аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2009 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ үндсэн чиглэлийн хэрэгжилтийг чухалчлан авч үзсэн билээ. Үндсэн чиглэлд нийт 191 зорилт тусгагдсан. Үүнээс, 0,0 хувийн гүйцэтгэлтэй 2, 30,0 хувийн гүйцэтгэлтэй 2, 50,0 хувийн гүйцэтгэлтэй 5, 70,0 хувийн гүйцэтгэлтэй 6, 90,0 хувийн гүйцэтгэлтэй 28, 100,0 хувийн гүйцэтгэлтэй 148

зорилт байна. Тэдгээрийн хэрэгжилтийн дундаж хувь нь 94,5, үнэлгээний оноо 4,72 байна. /Үндсэн чиглэлийн биелэлтийг энэ тайланд хавсаргав/

## Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

### **3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг төсвийн Ерөнхийлөн захирагч /сайд/ нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг тус тусын Яамдад 2010 оны эхэнд гаргаж хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нийт 9 төсвийн Ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргээ 93,3 хувиар биелүүлж, үнэлгээний оноо 4,66 байна. /Наймдугаар хавсралт/

Харьцангуй бага хувийн биелэлттэй байгаа зарим үүргийн талаар тайлбар хийхэд:

**1. Монгол улсын шадар сайдтай байгуулсан гэрээнд: Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийх зорилт 85,0 хувьтай гэсэн нь:**

Хэмжлийн эталон төхөөрөмж хэрэглэх зорилт хөрөнгийн боломжгүйгээс шийдвэрлэгдээгүй. Үүнд: усны тоолуурын тохируулгын эталон тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүний хүнд элемент болон хорыг тодорхойлох лабораторийн тоног төхөөрөмж авах нэн шаардлагатай байгаа. Төсөл боловсруулж холбогдох байгууллагуудад санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. Одоо байгаа тоног төхөөрөмж, техникээ ашиглаж, үйл ажиллагааны зорилтоо 85,0 хувиар биелүүлсэн байна.

**2. ХХААЖДҮ-ийн сайдтай байгуулсан гэрээнд: Хүнсний бүтээгдэхүүний хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах талаар зохиосон ажил 74,0 хувьтай гэсэн нь:**

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс болон аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийсэн үзлэг, шалгалтуудын дундаж хувиар энэ үнэлгээг гаргажээ. Тухайлбал, аймгийн МХГ-аас аймгийн төвийн хүнсний худалдаа эрхлэж буй 268 цэгт хяналт шалгалт хийхэд 85% нь ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан, 95% нь хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, чанар аюулгүй байдал, хүнсний сав баглаа боодол, шошгоны стандарт шаардлага хангасан байна. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 110 цэгт хяналт шалгалт хийхэд 77% нь батлагдсан жор технологийн дагуу дотоодын хяналт шалгалтын тогтолцоо нэвтрүүлсэн, 85% нь үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмжтэй, хадгалах нөхцлийн эрүүл ахуйн шаардлага хангасан, 80% нь ажлын байрны цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж, сав багаж хэрэгслийн угаалга ариутгал халдваргүйтлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 15 цэгт хяналт шалгалт явуулахад 87.5% нь бүтээгдэхүүнийг бэлтгэж боловсруулах технологи, урсгал зөв хийгдэж, 93.8 % нь төвлөрсөн усан хангамжтай, 70% нь хөргөгч, хөлдөөх төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж, хадгалах нөхцлийн эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй нөхцөлд үйл ажиллагаа эрхэлж байсан 1 гуанзны үйл ажиллагааг зогсоож,

хадгалалтын хугацаа дууссан, чанар, аюулгүй байдлаа алдсан 23 нэр төрлийн 382,7 мянган төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээ авсан байна.

**3. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээнд: „40 мянган орон сууц,, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт 75,0 хувьтай гэсэн нь:**

Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 2009 оны эхэнд аймгийн төв Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орон сууцны бичил хороололд хувийн болон орон сууц санхүүжилтийн корпорацийн хөрөнгө оруулалтаар 60, 30, 30, 65 айлын, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 20 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж байсан.

Замын- Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар 38, 48 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж байсан. 2009 оны сүүлийн хагас жилд Замын-Үүд суманд цагдаагийн ажилчдын 96 айлын нийтийн орон сууц, шүүхийн ажилчдын 48 айлын нийтийн орон сууц, багш нарын 30 айлын нийтийн орон сууцны барилгууд баригдаж эхэлсэн байна.

Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт орон сууцны санхүүжилтийн корпорацийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 20 айлын нийтийн орон сууцны барилга 2009 оны 7 дугаар сард ашиглалтанд орсон. Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 30 айлын орон сууц 2009 оны 11 дүгээр сард ашиглалтанд орсон.

Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт хувийн хөрөнгө оруулалтаар “Тулга констракшн” ХХК-ийн барьж буй нийтийн 32 айлын орон сууцны барилга 2009 оны 10 дугаар сард хэсэгчилэн ашиглалтанд орсон байна. Мөн багт “Говь-баяннуур” ХХК-ийн барьж буй 48 айлын нийтийн орон сууцны барилгын дотор заслын ажил үргэлжлэн хийгдэж байна.

2009 онд аймгийн хэмжээнд ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байсан орон сууцны барилгуудын 75,0 хувь нь ашиглалтанд орсноор гэрээний үүргийн биелэлтийг тооцсон болно.

**4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээнд: Ойжуулалтын ажил 76,3 хувьтай гэсэн нь:**

Аймгийн дүнгээр 36,6 мянган мод, суулгац тариалсан, Сайншанд сумын ойн зурвасыг өргөтгөсөн, хүлэмж байгуулсан, 5,0 мянган ш суулгац бэлтгэх боломжийг бүрдүүлсэн, „Ногоон хэрэм,, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 10 га талбайд ойн зурвас шинээр байгуулсан, түүнд 9,1 мянган мод тарьсан зэргээр ногоон байгууламжийг өргөтгөх ажил өмнөх жилийнхээс буураагүй байна. Харин нийт тарьсан суулгацын амьдарч байгаа хувиар гэрээний үүргийн биелэлтийг тооцжээ. Говийн нөхцөлд мод, бут, таримлыг суулгаад арчилж тордох ажил туйлын чухал, үүний дотор усны асуудал бэрхшээлтэйгээс үүдэн амьдралт 76,3 хувьтай байна

### **3.2.Төсвийн Ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

Төсвийн ерөнхийлөн захирагч-Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг аймгийн ЗДТГ-ын Ерөнхий менежер-ЗДТГ-ын дарга Б.Төмөрхуягтай 2009 оны 1 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтэнд хяналт шинжилгээ хийлээ.

Талууд гэрээгээ 2010 оны 1 дүгээр сарын 10 –ны өдөр дүгнэж, харилцан хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзсэн ба ЗДТГ-ын даргын үйл ажиллагаанд 90,0 хувь буюу 4,50 гэсэн үнэлгээний оноо өгчээ.

Б.Төмөрхуяг тайлант онд аймгийн ЗДТГ-ын хамт олныг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахдаа дараахь асуудлуудад онцгой анхаарч, холбогдох арга хэмжээ авч ажиллаж ирсэн байна.

1. Аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн ЗДТГ-ыг Төрийн захиргаа, удирдлагын /хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай/, Хууль зүйн /архивын тасагтай/, Хөгжлийн бодлогын, Нийгмийн хөгжлийн, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Цэргийн штабтай байхаар тогтоосон аймгийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 9-ны өдрийн 9 дүгээр захирамж гаргасан байна.

2. „Аймгийн ЗДТГ-ын 2009-2011 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө,, боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж ажиллуулсан юм. Аймгийн танилцуулга, түүх, байгууллагын хөгжлийн хэтийн зорилттой холбогдсон судалгааг өргөн хэмжээнд авч, тусгай асуумжаар иргэдээс судалгаа авсны үндсэн дээр боловсруулсан „Аймгийн ЗДТГ-ын 2009-2011 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө,,-г аймгийн Засаг даргын 2009 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 70 тоот захирамжаар баталсан байна.

3. Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 30 дугаар захирамж гаргаж, сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоосон байна. Хүн амын тоог харгалзан Сайншанд, Замын-Үүд сумдад 13, Айраг, Хатанбулаг сумдад 11, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумдад 10, Алтанширээ, Сайхандулаан сумдад 9 ажилтантай байхаар тус тус тогтоожээ.

4. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилтыг төсөв, хөрөнгийн боломжийг дайчлан шийдвэрлэж ирсэн байна. Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдыг суралцагч байгууллагын манлайллын сургалтанд бүрэн хамруулж ирсэн юм. Мөн тус Тамгын газрын ажилтнуудыг оролцуулахаар зарласан, төлөвлөсөн төв, орон нутгийн бүх шатны сургалтуудад холбогдох ажилтнуудыг бүрэн хамруулж, мэргэжил, мэдлэг, чадварын түвшнийг байнга дээшлүүлэх арга хэмжээ авч ирсэн байна. Ажилтнуудын 70,0 хувь нь байгууллага дээрхээс бусад ямар нэг шатны сургалт, семинар, зөвлөлгөөнд хамрагджээ.

5. Аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжүүд тодорхой хуваарийн дагуу ЗДТГ-ын хамт олонд мэдээлэл хийж, ажлаа танилцуулан, хамтын ажиллагааг хангаж ирсэн юм. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын дарга нарын зөвлөгөөнийг сард 2 удаа зохион байгуулж, аймгийн ажил төрлийн талаар мэдээлэл өгч, ойрын хугацаанд шийдвэрлэх зорилт, түүнд агентлагууд ямар үүрэгтэй оролцох талаар үүрэг чиглэл өгч байлаа. Мөн зөвлөгөөн бүр дээр 2-3 агентлагийн дарга нараар мэдээлэл хийлгэж, агентлаг хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ирлээ.

6. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг амжилттай хэрэгжүүлж ирсэн байна. Аймгийн хэмжээнд шударга ёс, ил тод байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах ажлын багийг Засаг даргын 2009 оны 411 дүгээр захирамжаар байгуулан ажиллуулж, түүнд төрийн бус байгууллагын төлөөлөл болох аймгийн ҮЭ-үүдийн Холбооны дарга, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний ахлагч, аймгийн ахмадын хорооны даргыг оролцуулсан байна. Ажлын хэсэг өргөн хүрээнд судалгаа авч уг төлөвлөгөөг үндэслэл сайтай боловсруулж, АТГ-аар хянуулахаар хүргүүлээд байна.

Бүх шатны төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй, хуульч, шудрага байдлыг хангуулах шаардлага тавьж ажиллаж ирсэн. Дорноговь аймгийн Засаг дарга төрийн албыг ил тод, шуурхай, шудрага, хуулийн хүрээнд явуулах зорилтыг гол бодлого болгож, үйл ажиллагааны хөтөлбөртөө төрийн алба „Өдөр бүр нээлттэй,, гэсэн зарчмыг томъёолж хэрэгжүүлж ирсэн болно. Аймгийн ЗДТГ-т “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг 2009 оны 7 дугаар сараас нээж ажиллуулан гол агентлагуудын төлөөллийг байнга ажиллуулж байна.

7. Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг явцын дунд болон жилийн эцэст үнэлж, холбогдох арга хэмжээ авч ирлээ. Жилийн эцсийн үнэлгээгээр нийт 34 ажилтан үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингээ үнэлүүлснээс 10 нь буюу 29,4 хувь нь А, 70,6 хувь нь В үнэлгээ авсан байна.

8. Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 37 тоот захирамжийн дагуу “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг,,-ийг 2009 онд зохион байгуулж явуулсан. Аймгийн Засаг даргын 2009 оны 189 дүгээр захирамжаар байгуулагдсан аймгийн салбар комисс 14 сум, 22 төрийн байгууллагад үзлэг явуулсан нь улсын үзлэгт хамрагдах сумдын 100,0 хувь, төрийн байгууллагуудын 80,3 хувь болж байгаа юм. Аймгийн дүнгээр 76,0 хувь буюу „хангалттай,, гэсэн үнэлгээ авсан. Төв комисс 2009 оны 9 дүгээр сард тус аймгийн ЗДТГ, 4 агентлаг, Замын-Үүд сумын ЗДТГ, 2 байгууллагад үзлэг явуулсан. Үүнээс аймгийн ЗДТГ 93,7 хувь буюу „Маш сайн,, гэсэн үнэлгээ авсан болно.

9. Бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар сум, хэлтэс газруудад аймгийн удирдлагаас 2 удаа үүрэг чиглэл өгч мөн өөрөө сумын Засаг дарга нарт 2 удаа, Засаг даргын орлогч нарт 1 удаа, сумын ЗДТГ-ын дарга нарт 1 удаа, агентлагийн дарга нарт 2 удаа, багийн Засаг дарга нарт 1 удаа, аймгийн ЗДТГ-ын ажилтнуудад 3 удаа тус тус эрхэлсэн ажлын чиглэлээр мэдээлэл өгсөн. Шинээр ирсэн, нийтэд мэдээлбэл зохих тогтоол, шийдвэрүүдийг агентлагийн дарга нарын зөвлөгөөн дээр тогтмол мэдээлж байв.

10. 2009 онд нийт 32 сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. Үүний дотор сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарын болон эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудын, мал аж ахуй эрхлэгчдийн, нийгмийн ажилтнуудын сургалт зөвлөгөөн семинарыг зохион байгуулжээ.

11. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн бүртгэл судалгааг 2009 оны байдлаар шинэчилсэн бүртгэлд оруулсан. Удирдах ажилтан болон хүний нөөцийн судалгааг шинэчлэн гаргасан. Одоогийн байдлаар 254 иргэн нөөцийн бүртгэлд бүртгэгдээд байна.

## **Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

### **4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал:**

Дорноговь аймгийн Засаг дарга төрийн албыг ил тод, шуурхай, шудрага, хуулийн хүрээнд явуулах зорилтыг гол бодлого болгож, үйл ажиллагааны хөтөлбөртөө төрийн алба „Өдөр бүр нээлттэй,, гэсэн зарчмыг томъёолж хэрэгжүүлж ирсэн болно. Энэ хүрээнд зохион байгуулсан гол ажил, арга хэмжээг тоймловол:

\* Аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлаг, төсөвт байгууллагуудыг цахим хуудастай болгож, түүнийг байнга шинэчилж байх эхлэлийг тавилаа.

\* Төрийн байгууллага бүр мэдээллийн самбартай болж, түүнд байгууллагын үйл ажиллагааны зорилт, иргэдэд үзүүлэх үйлчилгээний төрөл, тэрхүү үйлчилгээг авахын тулд иргэн өөрөө ямар баримт бичиг бүрдүүлэх, үйлчилгээний төлбөр, хураамжийг ямар эрх зүйгээр хэрхэн тогтоосон зэргийг байрлуулсан юм.

\* Аймгийн Төв номын сангийн “Мэдээллийн танхим”-ыг “Иргэдийн хөгжлийн төв” болгон өргөтгөж, интернетийн сүлжээнд холбож, ном хэвлэл, мэдээллийн эх сурвалжуудаар хангасан. Үүнд орон нутгийн төсвөөс 9.7 сая төгрөгийн хөрөнгө зарцууллаа.

\* Аймгийн ЗДТГ-т “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг 2009 оны 7 дугаар сараас ажиллуулж, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн үйлчилгээ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хадгаламж банк, аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдтэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг ажилтнууд байнга сууж иргэдэд үйлчилж байна. Тус төвөөр 2009 онд 8514 хүн үйлчлүүлжээ.

\* Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар зарим чухал бодлогын шийдвэр гаргахдаа олон нийтийн санаа бодлыг судалж, тусгах арга хэмжээ авдаг. Тухайлбал: Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулахдаа бүх сум, агентлагаас саналыг нь авч, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийг судалж, зайлшгүй шаардлагатай гэсэн асуудлуудыг тусган хэрэгжүүлж ирлээ. Мөн шударга ёс, ил тод байдлыг хангах төлөвлөгөө боловсруулахдаа ажлын хэсэг байгуулж ажиллууллаа. Уг ажлын хэсэгт төрийн албан тушаалтнуудаас гадна төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан юм. Ажлын хэсэг олон нийтийн саналыг тусгай хуудсаар авч төлөвлөгөөнд тусгасан юм.

\* Аймгийн Засаг даргын захирамжаар Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг телефон утсаар хүлээж авах журмыг баталж, мөрдөж байна.

\* Иргэд санал хүсэлтээ хүссэн үедээ, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангах зорилгоор Иргэдийн санал хүсэлт хүлээн авах байр гаргаж, түүнийг 2.5 сая төгрөгийн хөрөнгөөр засварласан. Тайлангийн хугацаанд уг байранд 200 гаруй иргэн ирж өргөдөл гомдол, санал хүсэлтээ тавин холбогдох хариуг авсан юм.

#### **4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:**

\* Аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг 2009 онд шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргын захирамжаар батлан мөрдөж ажиллаж байна. Уг хөтөлбөрт аймгийн хэмжээний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих асуудал тусгагдсан юм.

\* Байгууллагад шинээр орох албан хаагчдад байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулах, сул ажлын байрыг нийтэд зарлан сонгон шалгаруулах, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй иргэдээс ажлын байранд авах замаар хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

\* Сумд болон төрийн захиргааны байгууллагууд албан хаагчдын ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмыг байгууллагын ажилтнуудаар хэлэлцүүлэн баталж мөрдөж байна.

\* Аймгийн хэмжээнд 2009 онд багийн Засаг дарга нарын мэргэшлийн шалгалтыг нийт 238 иргэнээс авсан. Мөн Төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн сул орон тооны захиалгын дагуу төрийн албаны мэргэшлийн шалгалтыг

2009 оны 5 сард зохион байгуулсан. Уг шалгалтанд нийт 436 иргэн хамрагдсанаас 89 иргэн тэнцэж нөөцөд орж ажлын байраар хангагдаад байна. 2009 оны 12 дугаар сард нөхөн явагдсан мэргэшлийн шалгалтанд 308 иргэн оролцсоноос 188 иргэн тэнцэн онооны дарааллаар ажилд томилогдож байна. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 2009 онд нийт 8 байгууллагын захиалгаар 2 удаа зарлан зохион байгуулсан.

### **4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал:**

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа. Монгол Улсын Засгийн газраас баталсан аймгийн 2010 оны төсвийн орлого, зарлагын хязгаар Монгол Улсын төсвийн ил тод байдал /[www.iltod.gov.mn/](http://www.iltod.gov.mn/) цахим хуудаст тавигдсан.

Аймгийн 2010 оны орон нутгийн төсвийг 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын IY хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг МОНРТ-ийн Монголын мэдээ хөтөлбөрийн туузан мэдээгээр болон МОНЦАМЭ-гийн мэдээ сонины дугаарт нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн.

Аймгийн 2009 оны эхний хагас жилийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн [Dornogobi.gov.mn](http://Dornogobi.gov.mn) цахим хуудсанд байрлуулсан. Мөн аймгийн 2009 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Нэг цонхны үйлчилгээний цэг дэх мэдээллийн самбарт байрлуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн болно.

### **4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:**

\* 2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2009 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнд туссан асуудлуудын тендерийн урилгыг хуулийн дагуу “Зууны мэдээ” сонин болон [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) цахим сүлжээгээр нээлттэй зарласан. Үүнд, инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажил, аймгийн Нэгдсэн эмнэлгийн сантехник, лифтний засвар, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа, Замын-Үүд сумын хүүхдийн цэцэрлэгийн цэвэр усны шугамын их засвар, Даланжаргалан сумын соёлын төвийн их засвар, сургуулийн их засвар, Эрдэнэ сумын дотуур байрны их засвар зэрэг нийт 1389.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажлын тендерийг зарласан юм.

\* 2009 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд 1-2 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан аймгийн Засаг даргын захирамжаар томилж ажиллуулсан. Тендерт тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт тусган, сонирхсон этгээдэд саадгүй олгож, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг нээлттэй ил тод явуулж ирсэн.

\* 2009 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан 244.3 сая төгрөгийн өртөгтэй 10 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, 2009 оны төсвийн чөлөөт үлдэгдлээр 96.5 сая төгрөгийн өртөгтэй 8 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу орон нутгийн FM радио, телевизийн сувгаар зарлан, тендер шалгаруулалтын нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан.

\* Хуулийн дагуу нээлттэй зарласан тендерт оролцож, шалгарсан болон шалгараагүй компаниудын талаарх мэдээллийг Засгийн газрын веб сайтад тавьж,

тендер шалгаруулалтын талаарх ил тод байдлыг хангаж ажилласан. 2009 онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний улирал бүрийн тайланг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж байлаа. /Есдүгээр хавсралт/

## **Тав. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

### **5.1. Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн үнэлгээ:**

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгэр тогтоолоор баталсан журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргах эдийн засаг, нийгмийн 52 үзүүлэлтээс 1.13 /хураан авсан үр тариа/, 3.4 /улсын санд хүлээж авсан ойжуулсан талбай/ гэсэн 2 үзүүлэлт тус аймгийн хувьд дүгнэгдэх боломжгүй. Бусад 50 үзүүлэлтийн дундаж хувь 93,6, үнэлгээний оноо 4,68 байна. /Хоёрдугаар хавсралт/

2009 оны жилийн эцэст тус аймагт 57,7 мянган хүн оршин сууж байгаа нь өмнөх жилийнхээс 3,8 хувиар, 2000 оныхоос 14,1 хувиар нэмэгдсэн байна. Шилжин явсан хүний тоо шилжин ирсэн хүний тооноос 4,8 хувиар илүү байгаа ч хүн амын тоо ийнхүү нэмэгдсэн нь тус аймагт хүн амын цэвэр өсөлт улсын дунджаас дээгүүр байгаатай холбоотой. Төрсөн хүүхдийн тоо өмнөх оныхоос 12,4 хувиар өссөн байхад нас барсан хүний тоо 7,0 хувиар буурчээ.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн нийт хүн амд эзлэх хувь 18,7 байгаа нь өмнөх оныхоос 2,1 хувиар буурсан үзүүлэлт юм. Сумдын хувьд, ядуурлыг бууруулах талаар зохиосон гол ажил нь малжуулах арга хэмжээ байлаа. Аймгийн хэмжээнд 103 өрхийг нийтдээ 4635 толгой малтай болгожээ.

Харин хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо жилийн эцэст 532 болж өмнөх жилийнхээс 65,2 хувиар өссөн байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн бодлого хэрэгжсэнээр ажлын байр олноор нэмэгдэх боломжийг мэдэрсэн, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд бүртгүүлсэн хүмүүсээ сургалтанд хамруулах, байнгын ажлын байранд зуучлах, түр ажлын байраар хангах талаар өмнөх жилүүдээс ахицтай ажиллаж байгаа зэргээс тус байгууллагад бүртгүүлэх сонирхол нэмэгдсэн байх магадлалтай. Энэ нь бүртгүүлсэн нийт хүмүүсийн 75,0 хувь нь анхны удаа бүртгүүлсэн хүн байгаагаас харагдаж байна. Жилийн туршид, бүртгүүлсэн хүмүүсээс 956 нь ажилд зуучлагдаж бүртгэлээс хасагдсан байна.

Эрүүл мэндийн салбарын гол үзүүлэлтүүд сайжирсан дүнтэй байна. Эхийн эндэгдэл гараагүй, нялхсын эндэгдэл буурсан, халдварт өвчний гаралт өмнөх жилийнхээс 20,5 хувиар буурсан байна.

2009 оны мал тооллогын дүнгээр 1076,9 мянган толгой мал тоолуулж, 2000 оноос хойш 2 дахь удаагаа сая толгой малтай боллоо. Мал сүрэг бүх төрлөөрөө өссөний дотор үхэр, хонь, ямааны өсөлтийн хувь 16,5-15,9 хувь байна

Сүргийн дотор сайжруулсан нутгийн үүлдрийн мал 236,2 мянга болж өмнөх оныхоос 33,5 хувиар, нутгийн шилдэг омгийн мал 112,1 мянга болж өмнөх оныхоос 31,4 хувиар тус тус өссөн нь малын тоог биш, таваарлаг чанарыг голлох хандлага бий болсныг харуулж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого үр дүнгээ өгч өмнөх оноос тариалсан талбай 1,5 дахин, хураан авсан ургац 65,4 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 1,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2,3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Харин эдгээр тоо нь өмнөх оныхоос буурсан үзүүлэлт юм. „Дорнын говь,, ХХК орон нутагтаа мах

бэлтгэх, борлуулах үйлдвэрлэл явуулахгүй болсон, гэр ахуйн мод, төмрийн зэрэг зарим жижиг үйлдвэрлэл борлуулах зах зээл муутайгаас зогсонги байдалд орсон зэрэг нь гол шалтгаан болсон байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрээр 2 тэрбум 617,9 сая төгрөгийн үндсэн фонд ашиглалтанд оруулжээ. Үүний дотор 7,9 мянган кв.м талбай бүхий орон сууц ашиглалтанд орсон нь өмнөх оныхоос 46,2 хувиар илүү байна.

Харин улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оныхоос 44,5 хувиар буурч 3 тэрбум 116,2 сая төгрөг болсон нь улс орон даяар төсөв, санхүүгийн хямралтай байж, хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж буурсантай холбоотой.

2009 онд 7052,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төвлөрсөн төсөвт төлөх татварын орлогын төлөвлөгөөг 100,7 хувь, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 106,9 хувиар биелүүллээ.

Хэдийгээр төсөв санхүүгийн хямралтай байж, хөрөнгө оруулалтын хэмжээ багассан ч тус аймгийн хувьд эдийн засаг, нийгмийн онцын хүндрэл бэрхшээлгүй, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд өмнөх жилийнхээс сайжирсан жил байлаа гэж дүгнэж болохоор байна.

## **5.2. Хэрэглэгчийн үнэлгээ:**

Төр засаг болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын гаргасан шийдвэр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа болон төрийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар иргэдийн саналыг судлах ажлыг 2 удаа зохион байгуулсан юм.

### **5.2.1. Сумдын ЗДТГ зохион байгуулж авч явуулсан судалгаа:**

2009 оны 12, 2010 оны 1 дүгээр саруудад сумдын Засаг даргын Тамгын газруудад үүрэг чиглэл өгч иргэдээс санал авах ажлыг зохион байгууллаа. /Аравдугаар хавсралт/

2009 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд 57733 хүн оршин сууж байгаагийн 2,40 хувь буюу 1387 хүнээс уг санал асуулгыг авчээ. Судалгаа нийтдээ 40 асуулттай бөгөөд аймгийн хэмжээнд 55480 хариулт өгөгдсөн байна. /Хавсралт №10а/

Нийт асуултын 19,5 хувьд „мэдэхгүй,, гэсэн хариулт өгсөн нь төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажил хүн бүрт хүртээмжтэй биш, мэдээлэл хомс байгаатай холбоотой гэж үзэж байна. Мөн 19,2 хувь нь „хангалтгүй,, гэсэн хариулт өгсөн байна. Үндсэндээ 38,7 хувь нь сөрөг /муу/, 24,9 хувь нь дундаж түвшний, 36,2 хувь нь эерэг /сайн/ үнэлгээ өгсөн байна.

Иргэдийн ихэнх нь ядуу амьдарч, зуд турхан нүүрлэж, төр засгийн бодлого тууштай биш байгаад бухимдаж байна. Ялангуяа ядуу иргэдийн амьжиргааг тэтгэж байсан хүүхэд, шинээр гэр бүл бологсад, шинэ төрсөн хүүхдэд олгож байсан мөнгийг өгөхгүй болсон, хэдийгээр өөр хэлбэрээр, өөр сангаас хувь хишиг хүртээх болсон ч судалгаа авч байх үед тэр нь удаашралтай, чирэгдэлтэй байсан, сонгуулийн үеийн амлалтуудыг өгч чадахгүй болж уучлал гуйхад хүрээд байгаа зэрэг нь хүмүүст тааламжгүй сэтгэл төрүүлж, энэ санаагаа санал асуулгын хуудсаар илэрхийлсэн байна.

Хууль тогтоомжийн талаархи мэдээлэл, сурталчилгаа, хэрэгжилт ямар түвшинд байгааг харуулах нэгдүгээр бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариултыг 30,3 хувь нь өгсөн байхад „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 43,9 хувийг эзэлж байна.

Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө ямар түвшинд хэрэгжүүлж байгаа, төрийн захиргааны төв байгууллагуудын ажил, үйлчилгээ ямар түвшинд байгааг харуулах хоёрдугаар бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 33,2 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 39,9 хувийг эзэлж байна.

Аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн төр, захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээний үр дүнг харуулах гуравдугаар бүлэг асуултанд „бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 31,6 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 42,7 хувийг эзэлж байна.

Харин сумын ИТХ, Засаг дарга, сумын төр, захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээний үр дүнг харуулах дөрөвдүгээр бүлэг асуултын хариулт бусдаас арай дээр байна. „Бүрэн хангалттай,, „хангалттай,, гэсэн хариулт 46,6 хувь, „хангалтгүй,, „мэдэхгүй,, гэсэн хариулт 30,7 хувийг эзэлж байна.

Иргэд, олон түмний дунд байж, хүсэн хүлээсэн асуудлыг нь шийдвэрлэж байгаа сумын удирдлагуудад иргэд талархалтай ханддаг бөгөөд энэ чанараараа үнэлгээ нь муугүй байдаг. Дэлгэрэх, Даланжаргалан, Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдад санал асуулганд оролцогчдын 60,0-аас дээш хувь нь эерэг үнэлгээ өгсөн бол Хатанбулаг суманд дөнгөж 26,8 хувь нь сайнаар үнэлсэн байна.

Харин судалгааг хэн, хэзээ, ямар хүрээнд, зорилгоо хэрхэн ойлгуулж авснаас үр дүн өөр болдгийг бодолцох учиртай. Сумдаас ирүүлэх судалгаатай харьцуулж үзэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын ажлын хэсгүүд 2009 оны 10 дугаар сард бүх сумдад ажиллаж, сум бүрт 20-оос доошгүй хүнээс судалгаа авсан юм.

#### **5.2.2. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж авч явуулсан судалгаа:**

Судалгаанд нийгмийн янз бүрийн төлөөлөл оруулах, хөндлөнгийн нөлөөгүйгээр хариулах боломжийг олгох талаар дээрхи журамд заасныг хэрэгжүүлэх, ажлын хэсгийн гишүүд аль болохоор өөрсдөө уг судалгааг авах зорилго тавьсан болно.

Аймгийн хэмжээгээр 284 иргэнийг уг судалгаанд хамруулсны дотор малчин 48 /судалгаанд оролцогчдын 16,9 хувь/, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшилд ажиллагсад 71 /25,0 хувь/, төрийн албан хаагч 64 /22,5 хувь/, ажилгүй иргэд 61 /21,4 хувь/, өндөр настан 40 /14,0 хувь/ тус тус эзэлж байна. /Хавсралт №10б/

Оролцогч бүр 40 асуулттай судалгааны хүснэгт бөглөж, аймгийн дүнгээр 11360 асуултанд хариулсан ба тэдний 34,4 хувь нь төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилт, ажил үйлчилгээний чанарт бүрэн хангалттай, хангалттай гэсэн хариулт, харин 39,9 хувь нь хангалтгүй буюу мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. /Хавсралт №10в/

Иргэд сумынхаа Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны талаар арай илүү мэдээлэлтэй байж, нийт хариултын 46,0 хувь нь эерэг, өөдрөг байдлаар өгөгдсөн байхад хууль тогтоомжийн сурталчилгаа, түүний хэрэгжилт, Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд 41,9-46,3 хувь нь өөдрөг бус /хангалтгүй, мэдэхгүй гэсэн/ хариулт өгчээ.

Алтанширээ, Дэлгэрэх, Замын-Үүд сумд аймгийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны мэдээлэл арай сайн хүрч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнд иргэд дундаж түвшний үнэлгээ өгсөн байна. Хамгийн сайн үнэлгээ өгсөн сумд Алтанширээ, Иххэт, Замын-Үүд, Улаанбадрах, харин муу үнэлгээ өгсөн сумд Мандах, Айраг,

Сайхандулаан, Эрдэнэ сумд байна. Нийгэмд хэрэгтэй чухал асуудлыг шийдвэрлэсэн нь иргэдийн санаа сэтгэлд нөлөөлж, үнэлгээг дээшлүүлдэг нь Алтанширээ, Иххэт сумын жишээн дээр харагдсан болно. Алтанширээ суманд ундны усыг цэнгэгшүүлэх төхөөрөмж тавьж, энгийн амталгаагаар мэдэгдэх хэмжээнд хүргэж сайжруулсан, Иххэт суманд дулааны зуухны засварыг сайн хийж, дулаан хангамжийг өмнөх жилүүдийнхээс эрс сайжруулсан зэргийг уулзсан хүн бүр магтаж сайшааж байлаа.

Хэрэглэгчийн үнэлгээний хувийг тавихдаа дээрхи 2 судалгааны ерөнхий дүнгийн дунджийг авав. Тухайлбал, Сумдын ЗДТГ-аас авсан судалгаанд иргэдийн 80,7 хувь нь „хангалтгүй,-гээс бусад үнэлгээг, аймгийн ЗДТГ-аас авсан судалгаанд 80,0 хувь нь мөн үнэлгээг өгсөн бөгөөд дундаж нь 80,35 байна.

Тайланг бэлтгэсэн:

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСГИЙН ДАРГА**

Ц.ГАНБААТАР

Хянаж баталгаажуулсан:

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА**

Б.ТӨМӨРХУЯГ

2010 оны 3 дугаар сарын 4- ны өдөр

Сайншанд